



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2026 оны 03 сарын 04 өдөр

Дугаар A/162

Булган сум

Гэрээ байгуулах эрх олгох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэг, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдааны XII/90 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Сургуулийн барилгын их засвар (Хангал сум Хялганат тосгон)”-ын ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2026 оны 02 дугаар сарын 13-ны өдрийн хурлын зөвлөмжийн дагуу гүйцэтгэгчээр шалгарсан “Шинэзууны эрдэнэт” ХХК-тай 858,781,900 (найман зуун тавин найман сая долоон зуун наян нэгэн мянга есөн зуу) төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т олгосугай.

2.Гүйцэтгэж буй ажилд чанарын болон хугацааны хяналт тогтмол тавьж, хүлээн авахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар (Ү.Бямбасүрэн)-т даалгасугай.

3.Тус хөрөнгийг холбогдох хууль, журам, гэрээний дагуу хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавихыг Хялганат тосгоны захирагч (П.Отгондаваа)-д үүрэг болгосугай.

4.Гэрээнд заасан ажлыг холбогдох хууль, журам, стандарт, зураг, төсвийн дагуу гүйцэтгэж хүлээлгэн өгөхийг “Шинэзууны эрдэнэт” ХХК-ийн захирал (Э.Оюунбат)-д даалгасугай.

5.Гэрээнд тусгах нөхцөл шаардлагыг 1 дүгээр, тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус баталж, заагдсан үзүүлэлтүүдийг гэрээнд тусган хяналт тавин ажиллахыг хариуцсан албан тушаалтнуудад даалгасугай.

6.Тус ажлын санхүүжилтийг холбогдох хууль тогтоомж, гэрээний дагуу Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаас санхүүжүүлэхийг Аймгийн Засаг

**6326010218**


даргын тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Б.Ариунболд)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР


Аймгийн Засаг даргын 2026 оны  
03 дугаар сарын 04-ны/ний өдрийн  
А/162 дугаар захирамжийн 1 дүгээр хавсралт



Гэрээнд тусгах нөхцөл шаардлага

д/д	Нөхцөл шаардлага	Мөнгөн дүн	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4
1	Магадалшгүй ажил	14,911,997	Ү.Бямбасүрэн
2	Захиалагчийн техник хяналтын зардал	14,911,997	Ү.Бямбасүрэн
3	Зураг төсөл зохиогчийн хяналтын зардал	7,455,998	Ү.Бямбасүрэн
4	Инженер хайгуул, зураг төслийн ажлын дүн	25,000,000	Ү.Бямбасүрэн
5	Нормчлолын сан	1,342,080	Ү.Бямбасүрэн
6	Алданги	Хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна. Нийт алдангийн хувь гүйцэтгээгүй үүргийн 10 хувиас хэтрэхгүй байна.	Б.Ариунболд
7	Чанарын баталгаа	Гэрээний үнийн дүнгийн 5 хувь, чанарын баталгааг байршуулах банк, дансыг гэрээнд тусгана.	Б.Ариунболд Ү.Бямбасүрэн
8	Гүйцэтгэлийн баталгаа	3 хувь	Б.Ариунболд
9	Ажил гүйцэтгэх хугацаа	Хуанлийн 60 хоног	Ү.Бямбасүрэн

Аймгийн Засаг даргын 2026 оны  
03 дугаар сарын 04 нын өдрийн  
... А/162 дугаар захирамжийн 2 дугаар хавсралт



Тухайн төсөл арга хэмжээг гүйцэтгэхээр санал болгосон инженер, техникийн ажилчид, машин механизмын жагсаалт

Инженер, техникийн ажилчид			Хариуцах албан тушаалтан
д/д	Албан тушаал	Ажилтны нэр	
1	2	3	4
1	Барилгын инженер	С.Ганзориг	Ү.Бямбасүрэн
2	Цахилгааны инженер	Б.Баасандалай	
3	Усан хангамж, ариутгах татуургын инженер	Б.Лхагвасүрэн	
4	Дулааны инженер	Р.Болд-Эрдэнэ	
5	Холбоо дохиолол, мэдээллийн инженер	Ч.Алтансүвд	
6	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн ажилтан	Э.Оюунбат	
Машин механизмын жагсаалт			Ү.Бямбасүрэн
№	Машин механизмын нэр	Улсын дугаар	
1	Автокран	4723 ОРО	
2	Ачааны автомашин	8370 ОРБ	
3	Экскаватор	1613 УР	

--о00о--